13.1 Төгсөлт бүртгэж, баталгаажуулах үйл ажиллагаа

Энэ хэсэгт Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн суралцагчдыг хичээлийн жилийн эцэст төгсгөх болон тухайн ангид нь давтан суралцуулах үйлдлийг дараах алхамын дагуу гүйцэтгэнэ.



Анхаарах:

- Заавал болон сонгон судлах хичээлийн дүнг бүлгийн сурагч бүрээр бүртгэж баталгаажуулсан байх шаардлагатай.
- Суралцагчийн судлагдахууны дүнгийн бодолт хийгдэж батлагдсан байх шаардлагатай.
- Баталгаажуулах хүсэлт илгээхээс өмнө Бүртгэлийн маягтыг заавал татан авч шалгах шаардлагатай.
- Баталгаажуулах хүсэлт илгээсэн үед Бүртгэлийн маягтанд засвар оруулах боломжгүй. Хэрэв илгээсэн бүртгэлийн маягтанд залруулга оруулах тохиолдолд БСУГ/БХ мэргэжилтнээр заавал төгсөлтийн буцаалт хийлгэсний дараа залруулга хийж бүртгэлийн маягтыг дахин татан авч шалгасаны дараа дахин төгсөлт баталгаажуулах хүсэлт илгээж болно.
- Бүртгэлийн маягтанд бичигдсэн суралцагчийн овог, нэр, регистрийн дугаар, хичээл болон улсын шалгалтын үнэлгээ, сурлагын үнэлгээний дундаж хувь нь Боловсролын баримт бичигт хэвлэгдэнэ.

1. **АУБ:** Төгсөх шалгуур хангасан болон тухайн түвшинд давтан суралцах суралцагчийг төгсөлтийн бүртгэлд бүртгэнэ. Бүртгэл нь “Бүртгэгдсэн” төлөвт шилжинэ.

2. **Сургалтын менежер:** Бүлгүүдийн төгсөлтийн бүртгэлийн жагсаалтыг хүлээн авна.

3. **Сургалтын менежер:** Төгсөлтийн бүртгэлийг хянаж үзээд төгсөх болон давтан суралцах сурагчдын бүртгэлийг баталгаажуулалт хийлгэхээр БСУГ/БХ -ийн мэргэжилтэнд илгээнэ. Баталгаажуулах хүсэлт илгээхээс өмнө Бүртгэлийн маягтыг заавал татан авч шалгах шаардлагатай. БСУГ -т илгээсэн төгсөлтийн

бүртгэл нь “Хянагдаж байгаа” төлөвтэй байна. Төгсөлтийн бүртгэлийг буруу эсвэл алдаатай гэж үзвэл цуцлах үйлдэл хийж АУБ-д бүртгэлийг буцаана. Буцаагдсан бүртгэл нь “Цуцлагдсан” төлөвтэй болно.

4. **БСУГ/БХ мэргэжилтэн:** Сургуулиудаас төгсөлт баталгаажуулах хүсэлтийг хүлээн авна. Шийдвэрлээгүй хүсэлт нь”Хянагдаж байгаа” төлөвтэй байна.

5. **БСУГ/БХ мэргэжилтэн:** Төгсөлтийн бүртгэлийг хянаад шийдвэр гаргана.